



УЛСЫН ХОЁРДУГААР ТӨВ ЭМНЭЛГИЙН 2026 ОНЫ **ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ САЙЖРУУЛАХ** ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ 1 ДҮГЭЭР УЛИРЛЫН ТАЙЛАН (ЭМС-ын 2024 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн А/112 дугаар тушаалын дагуу)

2026 оны 03 дүгээр сарын 20 өдөр



**Чанарын Бодлого:** Дэвшилтэт технологи, чадварлаг мэргэжилтнийг хөгжүүлж, олон улсын чанарын менежментийн тогтолцоог хэрэгжүүлж, үйлчлүүлэгч төвтэй, хүн амд чанартай аюулгүй цогц эрүүл мэндийн тусламж үйлчилгээг хүргэхэд оршино.

**2026 оны Зорилго:** Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулахын хүрээнд дотоод хяналтын давтамж, чанар түүний үр нөлөөг сайжруулах, ISO 9001:2015 Олон улсын стандарт болон үндэсний магадлан итгэмжлэлийн үнэлгээнд орох.

Д/д	Үйл ажиллагаа	Шалгуур үзүүлэлт	Хүрэх үр дүн	Хийсэн ажил
<b>Зорилт 1: Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгох, удирдлагын манлайллыг бэхжүүлэх, тусламж, үйлчилгээний чанар аюулгүй байдлыг тасралтгүй хэмжиж сайжруулах</b>				
1.1	Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн байгууллагаар ISO 9001:2015 Чанарын менежментийн тогтолцоо стандартын хэрэгжилтэд явцын үнэлгээ хийх, стандартыг сунгуулах	Томилогдсон ажлын хэсэг стандартын хэрэгжилтийн шалгуур үзүүлэлт бүр дээр хяналт хийж, үл тохирол илрүүлэн залруулсан үл тохирлын тоо. Стандартын сунгалт	Стандартын хэрэгжилт, үйл ажиллагаа сайжирна. Стандартын хүчинтэй хугацаа сунгагдсан байна.	Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн эрх бүхий байгууллагаар (TQCSI Mongolia LLC) ISO 9001:2015 Чанарын менежментийн тогтолцоо стандартын баталгаажилтыг сунгуулахаар гэрээ байгуулсан. Санхүүжилтийн асуудал шийдэгдээгүй тул үйл ажиллагаа түр хойшилсон байна.

1.2	<p>Эмнэлгийн хэмжээнд хийх дотоод аудитын нэгдсэн хөтөлбөрийг гаргаж, хөтөлбөрийн дагуу аудит хийх. Тасаг, албад дотоод аудитын хуваарийн дагуу тогтмол хяналт хийх.</p>	<p>Батлагдсан дотоод аудитын нэгдсэн хөтөлбөр болон дотоод хяналтын хуваарь, тайлан. Илэрсэн үл тохирлын тоо, залруулсан тоо</p>	<p>Стандарт, удирдамж, ажлын заавар, журмын мөрдөлт сайжирсан байна.</p>	<p>Эмнэлгийн хэмжээнд 2026 оны дотоод аудит хийх нэгдсэн хөтөлбөрийг нийт 12 чиглэлээр гарган эмнэлгийн удирдлагаар батлуулсан.</p> 
1.3	<p>Дотоод хяналт, үнэлгээ хийх төлөвлөгөө гаргаж, төлөвлөгөөний дагуу тогтмол хяналт хийх</p>	<p>Дотоод хяналт үнэлгээ хийх журам гаргах. Батлагдсан хяналт, үнэлгээний нэгдсэн төлөвлөгөө болон хуваарь, тайлан. Боловсруулан гаргасан хяналтын хуудсын төрөл, тоо. Илэрсэн үл тохирлын тоо, залруулсан тоо</p>	<p>Стандарт, удирдамж, ажлын заавар, журмын мөрдөлт, эмнэлгийн тусламж үйлчилгээний чанарын баталгаажилт 95%-иас доошгүй болсон байна.</p>	<p>Эмнэлгийн хэмжээнд Дотоод хяналт үнэлгээ хийх хуваарийг нийт 21 чиглэлээр гаргаж ЭМТҮЧАБЭ-ийн албаны даргаар батлуулсан. Дотоод хяналт үнэлгээг 2026.01.12-03.11 хооронд нийт 8 удаа хяналт үнэлгээг хийсэн. Дотоод хяналт үнэлгээгээр нийт 83 үл тохирол илэрсэн. Нийт 53 зөвлөмж өгсөн.</p> <p>Дотоод хяналт үнэлгээ хийх хуваарь</p> 

№	Чиглэл	Хугацаа	Тасаг, нэгж	Үл тохирлууд	Зөвлөмж
1	ЭМС-ын 2025 оны А/408 тоот тушаал, УХТЭ-ийн "Мансууруулах болон сэтгэц нөлөөт эмийн журам"-ын хэрэгжилт.	2026.01.12	ЭЭТ, ХБЭСТ, МСТ, Харвалтын нэгж, Шигдээсийн А, Б нэгж, Мэс заслын 2, Гемодиализын хэсэг, ЯТТ	7	8
2	ЭМЯ-ны 2025 оны А/408 тоот тушаал, УХТЭ-ийн "Мансууруулах болон сэтгэц нөлөөт эмийн журам"-ын хэрэгжилт.	2026.01.12	Ерөнхий мэс заслын тасаг ХБЭСТ, Харвалтын нэгж, Шигдээсийн Гемодиализын хэсэг, ЯТТ, Мэс заслын 2	Өвчний түүхээс -1 Эм тарианы өрөө -3	5
№	Чиглэл	Хугацаа	Тасаг, нэгж	Үл тохирлууд	Зөвлөмж
3	Эм эмнэлгийн хэрэгслийн тасалдалтай холбогдуулан хяналт хийсэн тухай	2026.01.28	Эмзүй хангамжийн алба, ТХЧХНСМЗТ	5	3
4	Магадлан итгэмжлэлийн гэрчилгээ сунгахтай холбоотой тасгийн бэлэн байдал, ЭМС-ын тушаал А/536, А/537, А/538, А/539, А/173, А/193	2026.01.30	Ариутгал халдваргүйтгэлийн тасаг	Ариутгалын хэсэг – 9 Угаалгын хэсэг -7	Ариутгалын хэсэг – 9 Угаалгын хэсэг -3 Халдвар судлаач эмч -6
№	Чиглэл	Хугацаа	Тасаг, нэгж	Үл тохирлууд	Зөвлөмж
5	Өвдөлт намдаах хэсэгт хийсэн дотоод аудитын тайлан	2026.02.05	МЭЭТ-Өвдөлт намдаах хэсэг	Өвдөлт намдаах - 10 Үзлэг өрөө- 2	10
6	Магадлан итгэмжлэл болон ISO 9001:2015 стандартын баталгаажилтыг сунгах ажиллагаатай холбоотой тасгийн бэлэн байдал, ЭМС-ын тушаал А/415, А/184, А/408	2026.02.06	Эм зүйн алба	5	11
1.4	Магадлан итгэмжлэлд бэлтгэх ажлын хэсгийн гаргасан тушаал, ажлын хуваарийн дагуу ажиллах	Магадлан итгэмжлэлд бэлтгэх ажлын хэсгийн үйл ажиллагааны батлагдсан хуваарийн дагуу хийсэн ажлын тайлан	Магадлан итгэмжлэлд бэлтгэх үйл ажиллагаа хангагдсан байна.	Улсын хоёрдугаар төв эмнэлэг 2026 оны 12 дугаар сард магадлан итгэмжлэлийн үнэлгээнд орох тул бэлтгэл ажлыг хангах зорилгоор Эмнэлгийн захирлын А/179 тоот тушаалаар магадлан итгэмжлэлд бэлтгэх ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг баталсан. Уг тушаалын 1 дүгээр хавсралтаар Магадлан итгэмжлэлд бэлтгэх ажлын хуваарийг, 2	

				<p>дугаар хавсралтаар магадлан үнэлэх шалгуурын дагуу үнэлгээ хийх хуваарийг тус тус баталсан.</p>  <p>УЛСЫН ХОЁРДУГААР ТӨВ ЭМНЭЛГИЙН ЗАХИРЫН ТУШААЛ</p> <p>2023 оны 08 сарын 10 өдөр Дугаар 4/2023 Улаанбаатар хот</p> <p>2026 онд магадлан итгэмжлэлд бэлтгэх ажлын хэсэг байгуулах тухай</p> <p>Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/554 дугаар тушаал, 2023 оны А/412 дугаар тушаалыг үндэслэн ТУШААХ нь:</p> <ol style="list-style-type: none"> <li>Улсын хоёрдугаар төв эмнэлэг 2026 оны 12 дугаар сард магадлан итгэмжлэлийн үнэлгээд орох тул бэлтгэл ажлыг хангах зорилгоор Ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай. Ажлын хэсгийн ахлагч: З.Арьяасүрэн - ЭМТҮЧАБА-ны дарга Нарийн бичиг: Б.Дулмаа - ЭМТҮЧАБА-ны Чанарын менежер Гишүүд: Б.Гэгээбадрах- ХБЭС-ийн тасгийн эрхлэгч Д.Батжаргал- Нүд судлалын тасгийн эрхлэгч П.Дуламрагчаа- Мадрал судлалын тасгийн эрхлэгч Б.Дөлгөөн- Тусгай тасгийн эрхлэгч Ж.Уламсайхан- Яаралтай тусламжийн тасгийн эрхлэгч Б.Мөнгөншүр- Эмнэлгийн үйл ажиллагаа зохицуулалтын тасаг Д.Нацагсүрэн- Сувилахуйн албаны дарга Ц.Уянга- Ариутгал халдваргүйтгэлийн тасгийн эрхлэгч С.Анхтуяа- Нэгдсэн лабораторийн тасгийн эмч</li> <li>Магадлан итгэмжлэлд бэлтгэх ажлын хуваарийг нэгдүгээр хавсралтаар, магадлан үнэлэх шалгуурын дагуу үнэлгээ хийх хуваарийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.</li> <li>Ажлын хэсгийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Эмнэл зүй хариуцсан дэд захирал (Ц.Ганзориг), ажлын хэсгийн ахлагч ЭМТҮЧАБА-ны дарга (З.Арьяасүрэн) нэрт тус тус даалгасугай.</li> </ol> <p>ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ  З.АНХБАР</p> <p>20251171</p>
--	--	--	--	---



			зүйлийг бодитоор тодорхойлж, урьдчилан сэргийлнэ.	(нийт 11 журам) <ul style="list-style-type: none"> <li>- Нийт чанарын шалгуур үзүүлэлтийг шинэчлэх, үлгэрчилсэн загварт оруулах тухай</li> <li>- Ажилбарын жагсаалтыг шинэчлэн гаргах</li> <li>- Эмнэлзүй ба эмгэг судлалын бага хурлаас гарсан шийдвэрийг танилцуулах</li> <li>- Оношны хэлбэржүүлэлтээр нийт эмч нарт сургалт хийх тухай</li> </ul>
1.6	Гадаад аудитын зөвлөмжийн дагуу хийх ажлыг зохион байгуулах	Гадаад аудитын үр дүн, зөвлөмжийн дагуу хийгдсэн ажлын тайлан	Стандарт, удирдамж, ажлын заавар, журмын мөрдөлт сайжирсан байна.	1-р улиралд гадаад аудит буюу хяналт үнэлгээ хийгдээгүй.
1.7	ISO 9001:2015 Чанарын менежментийн тогтолцоо стандартын шаардлагын дагуу удирдлагын дүн шинжилгээ хийх	Удирдлагын дүн шинжилгээний тайлан	Удирдлагын дүн шинжилгээг журмын дагуу хийж, сайжруулах арга замыг тодорхойлсон байна.	Удирдлагын дүн шинжилгээ хийх тухай журмын дагуу хагас жилд хийгдэнэ.
1.8	Эмнэлгийн удирдлагын зөвлөл болон дунд шатны менежерүүдэд ISO 9001:2015 стандарт болон Магадлан итгэмжлэлийн тухай сургалт орох	Сургалтын бүртгэл, тайлан. Сургалтын өмнөх болон дараах мэдлэгийн түвшин	Эмнэлгийн удирдлагын зөвлөл болон дунд шатны менежерүүдэд ISO 9001:2015 стандарт болон Магадлан итгэмжлэлийн талаарх мэдлэгийн түвшин сайжирсан байна.	Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн эрх бүхий байгууллагаар (TQCSI Mongolia LLC) ISO 9001:2015 Чанарын менежментийн тогтолцоо стандартын сургалт хийхээр төлөвлөгдсөн боловч санхүүжилттэй холбоотой хийгдээгүй байна.
<b>Зорилт 2: Чанар сайжруулах арга хэрэгсэл нэвтрүүлж, хэрэгжүүлэх, чанарын өвөрмөц шалгуур үзүүлэлтийг боловсруулах</b>				
2.1	ISO 9001:2015 Чанарын менежментийн тогтолцооны стандартын дагуу баримтжуулсан мэдээллийг	Хянан, магадалж шинэчилсэн, шинээр боловсруулж баталгаажуулсан	Эмнэлгийн тусламж үйлчилгээний стандарт, журам, зааврууд г.м баримтжуулсан	2026 оны 1 дүгээр улиралд нийт 5 журам шинэчлэн батуулсан. Үүнд:


	<p>хянан магадлах (зөрүүний шинжилгээ хийх), шинэчлэх, шинээр боловсруулах (JCI стандартад тохируулж хийнэ)</p>	<p>баримтжуулсан мэдээллийн тоо</p>	<p>мэдээллүүд тодорхой болж, тусламж үйлчилгээний чанар сайжирна.</p>	<ol style="list-style-type: none"> <li>1. Эмнэлгийн тусламж үйлчилгээний талаар гаргасан өргөдөл, гомдол, саналыг шийдвэрлэх тухай журам</li> <li>2. Эмнэлгийн ажилтан болон өвчтөн түүний гэр бүлээс сэтгэл ханамжийн судалгаа авах тухай журам</li> <li>3. Эмнэл зүй ба эмгэг судлалын бага хурал зохион байгуулах тухай журам</li> <li>4. Эмч нарын хамтарсан зөвлөгөөн (консилиум) хийх тухай журам</li> <li>5. Сахиур болон эргэлтийн үйл ажиллагааг зохицуулах журам</li> </ol> <p>Эдгээр журмуудыг шинэчлэхдээ олон улсын стандарт болон JCI стандартын шаардлагад нийцүүлэн холбогдох өөрчлөлтүүдийг тусган батлуулсан. Цаашид Жижүүр эмчийн үйл ажиллагааны журам, Зөвлөх эмч болон төрөлжсөн мэргэшлийн эмчийн үзлэг хийх журам, Ижил мэргэжилтний үнэлгээ хийх тухай журмуудыг шинэчлэн боловсруулан, санал авах шатандаа явж байна.</p>
<p>2.2</p>	<p>Тохиолдол, үл тохирлыг бүртгэх, дүн шинжилгээ хийж, урьдчилан сэргийлэх-Улирал бүр тасгуудын тайланг авна.</p>	<p>Тохиолдол, үл тохирлын санд бүртгэгдсэн тоо, хүнд ноцтой тохиолдлын буурсан тоо</p>	<p>Эмнэлгийн нөхцөлд гарах тохиолдол, үл тохирлын тоо буурч, тусламж үйлчилгээний аюулгүй байдал сайжирна.</p>	<p>Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдал эрсдэлийн алба нь “Үл тохирол, тохиолдол бүртгэх, мэдээлэх, хариу арга хэмжээ авах тухай журам УХТЭ-БМ-06 ЧМТЖ 2:2025-5” журам, Эрүүл мэндийн сайдын 2024 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн А/112 дугаар тушаалын дагуу үл тохирол, тохиолдол, алдааг бүртгэж, цахим сан үүсгэн, шаардлагатай тохиолдолд</p>


				<p>холбогдох тасаг ажилтнуудтай хамтран хэлэлцэж залруулах сэргийлэх арга хэмжээг авч ажилласан.</p> <p>2025 оны 03 дугаар сарын 20-ны байдлаар нийт 55 тохиолдол бүртгэгдсэн. Эдгээр 55 тохиолдлоос:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Халдварын сэргийлэлт хяналтын албанаас бүртгэсэн 20 тохиолдол нь ЭТҮХХ-ын нийт тоо бөгөөд үүнээс Зохиомол амьсгалын аппараттай холбоотой уушгины хатгалгаа - 5, МЗДШХ -15, байна.</li> <li>- Мэс заслын тасгуудаас бүртгэгдсэн Давтан хагалгаа 10</li> <li>- ЭМТҮЧАБ-ын албанаас гаргасан тохиолдол үл тохирол бүртгэх дотоод цахим санд нийт тасаг нэгжүүдээс 25 тохиолдол, үл тохирол бүртгэгдсэн.</li> </ul> <p>Эрүүл мэндийн сайдын 2024 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн А/112 дугаар тушаалд заасан ангиллаар авч үзвэл: Эмнэлзүйн бус шалтгаантай тохиолдол нийт 15 (27.2%), Эмнэлзүйн шалтгаантай тохиолдол нийт 40 (72.7%) бүртгэгдсэн байна.</p> <p>Нийт 55 тохиолдлоос Кодын зэрэглэлээр ангилж үзвэл</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Алдах дөхсөн тохиолдол буюу 1А - 15 (27.2%)</li> <li>2. Тохиолдол буюу 1Б – 36 (65.4%)</li> </ol>
--	--	--	--	---

				<p>3. Таагүй тохиолдол буюу 2 – 3 (5.4%)</p> <p>4. Ноцтой тохиолдол буюу 3 – 1 (1.8%)</p>
2.3	Ижил мэргэжилтний үзлэг, стандарт, журмын хэрэгжилтийн хувийг тооцож ажиллах	Ижил мэргэжилтний үзлэгийн тоо, стандарт мөрдөлтийн хувь	Стандарт, удирдамж, ажлын заавар, журмын мөрдөлт сайжирсан байна.	Эмнэлгийн хэмжээнд тасгуудын чанарын багуудаас нэгтгэн үзэхэд эмч нар нийт 6 удаа 80 өвчний түүхэнд, 10 удаа ажилбар, түгээмэл үйлдлүүдийг хянах чиглэлээр ижил мэргэжилтний үнэлгээ хийсэн. Сувилагч нар нийт 6 чиглэлээр 309 удаа ижил мэргэжилтний үнэлгээ хийсэн.
2.4	Чанар сайжруулах аргууд болох 5S, фокус бүлгийн ярилцлага, шалтгаан үр дагаврын шинжилгээ, парето, ишикава диаграм гэх мэт аргуудыг өргөн ашиглах.	Ашигласан арга, хэрэгслийн тоо, нэвтрүүлсэн байдал	Чанар сайжруулах олон арга, хэрэгслүүд бий болсноор үйлчлүүлэгчид үзүүлж буй тусламж үйлчилгээ сайжирна	<ul style="list-style-type: none"> <li>- ДОТ-т хэвлийн тодосгогчтой КТГ-ийн шинжилгээний үед тодосгогч бодис судсаар хийх үед судас хагарч хавдаж улайсан таагүй тохиолдол гарсан. Сувилахуйн алба, ЭМТҮЧАБЭА, Дүрс оношилгооны тасаг, ЦОЭТ хамтран чанар сайжруулах арга хэрэгсэл болох Ишакава диаграм болон парето диаграм ашиглан хэлэлцсэн. Үүнээс 8-н үйл ажиллагааны төлөвлөгөө гарган, хэрэгжүүлж ажиллаж байна.</li> <li>- МЭЭТ-т бүртгэгдэж буй Зохиомол амьсгалын аппараттай холбоотой уушгины хатгааны тохиолдлыг бууруулах хариу арга хэмжээний үйл ажиллагааны хүрээнд АХТ-тай хамтран 3 зорилт 29 үйл ажиллагаа төлөвлөсөн. Үүний хүрээнд Ишикава диаграм болон парето диаграм ашиглан цаашид хэрэгжүүлэх гол тулгамдсан</li> </ul>

				асуудлуудыг гарган Удирдах зөвлөлөөр хэлэлцүүлэн ажилласан.
2.5	Чанар аюулгүй байдал сайжруулах аян өрнүүлэх	Аяны тоо, үйл ажиллагаанд оролцсон байдал	Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар сайжирна. Нийт ажилтны оролцоо, идэвх нэмэгдэнэ.	2, 4-р улиралд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн
2.6	Тасаг бүрийн чанарын өвөрмөц шалгуур үзүүлэлтүүдийг гаргаж, үнэлгээ дүгнэлт өгөх (тасаг бүр өвөрмөц шалгуур үзүүлэлтийг сар бүр ЭМТҮЧАБЭ-ийн албанд мэдээлнэ.)	Чанарын өвөрмөц шалгуур үзүүлэлтүүдийг сар, улирлаар тооцож ажиллах	Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанарын түвшинг тогтоож, чанарын үзүүлэлтүүдийг хангаж ажиллана.	Нийт эмнэлгийн хэмжээнд 114 өвөрмөц шалгуурыг тооцон ажиллаж байна. Эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулах зөвлөлийн хурлаар хэлэлцэн дараах зүйлсийг багтаасан жишиг үлгэрчилсэн загварын дагуу алба тасаг тус бүр чанарын өвөрмөц шалгуур үзүүлэлтийг шинэчлэн гаргаж байна. Үүнд: 1. Чанарын шалгуур үзүүлэлтийн нэр (товчлол) 2. Тодорхойлолт 3. Үндэслэл 4. Чанарын шалгуурын төрөл (орц, үйл явц, гарц, өвчтөний аюулгүй байдал) 5. Тооцоолох арга, томьёо 6. Хамрах хүрээ (хасагдах шалгуур) 7. Эх сурвалж 8. Суурь түвшин 9. Жишиг түвшин, хүрэх түвшин
2.7	Тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдлын чиглэлээр үр дүнтэй, бүтээмжтэй ажилласан алба,	Урамшуулалд хамрагдсан алба, тасаг, нэгж, ажилтны тоо, олгосон урамшууллын мөнгөн дүн	Эмнэлгийн тусламж үйлчилгээг сайжруулах ажилд оролцох алба, тасаг, нэгж, ажилтны	2, 4-р улиралд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн.

	тасаг, нэгж, ажилтныг урамшуулах		идэвх болон ажлын бүтээмж нэмэгдэнэ.	
<b>Зорилт 3: Хүний нөөцийг бэхжүүлэх, чадавхжуулах</b>				
3.1	Чанарын чиглүүлэх сургалтуудыг тасралтгүй хийх (чанар, аюулгүй байдлын чиглэлээр, халдварын сэргийлэлт, өвчний түүх бичилт, эмнэлзүй заавар удирдамж гэх мэт)	Сургалтын тоо, хамрагдсан ажилтны тоо, үр дүнг үнэлсэн байдал	Эмнэлгийн ажилтнуудын чанар, аюулгүй байдлын тухай хандлага, мэдлэг, чадвар сайжирна.	<ul style="list-style-type: none"> <li>- Яаралтай тусламжийн тасгийн эмч сувилагч нарт “Эрсдэлийн удирдлагын журам”-ын танилцуулга болон Эрсдэлийн тухай ойлголт, “Үл тохирол, тохиолдол бүртгэх, мэдээлэх, хариу арга хэмжээ авах тухай журам”-ын танилцуулга болон тохиолдол бүртгэх мэдээлэх, хариу арга хэмжээ авах тухай Эрсдэл, аюулгүй байдал хариуцсан менежер Б.Номин, Чанарын менежер Б.Жаргалмаа нар сургалт орсон.</li> <li>- МЭЭТ-ийн эмч сувилагч нар шинэчилсэн 11 журмын танилцуулга болон Эрсдэлийн тухай сургалтыг Эрсдэл, аюулгүй байдал хариуцсан менежер Б.Номин, Чанарын менежер Б.Жаргалмаа нар сургалт орсон.</li> <li>- Сувилахуйн алба болон ахлах сувилагч нарт тохиолдол бүртгэх мэдээлэх, хариу арга хэмжээ авах тухай болон Шалтгаан үр дагаврын шинжилгээ сэдвээр Чанарын менежер Б.Дулмаа сургалт орсон.</li> <li>- Дүрс оношилгооны төвийн нийт эмч, сувилагч, техникч нарт шинэчилсэн 11 журмын танилцуулга болон Тохиолдол бүртгэх мэдээлэх хариу арга хэмжээ авах болон Оношилгоотой холбоотой тохиолдлуудад Үндсэн шалтгааны дүн шинжилгээ хийх тухай Чанарын менежер</li> </ul>

				Б.Дулмаа, Чанарын менежер Б.Жаргалмаа нар сургалт орсон.
3.2	Мэргэжил дээшлүүлэх сургалтыг тогтмол зохион байгуулах	Сургалтын тоо, хамрагдсан ажилтны тоо, үр дүнг үнэлсэн байдал	Хүний нөөцийн чадавх сайжирна.	Сургалтын албаны тайланд дэлгэрэнгүй тусгагдсан болно.
3.3	Чанарын өдөрлөг, чанарын багууд хуваарийн дагуу тогтмол хийх	Чанарын өдөрлөгийн тоо, үр дүнг үнэлсэн байдал	Эмнэлгийн ажилтнуудын чанарын тухай хандлага, мэдлэг, чадвар сайжирна.	<p>- Дэлхийн Глаукомын долоо хоног Жил бүрийн 3 дугаар сарын 8–14-ний өдрүүдэд Нүдний даралт ихсэх өвчинтэй тэмцэх дэлхийн 7 хоног тохиодог. Энэ аяны хүрээнд Улсын хоёрдугаар төв эмнэлэг болон Улсын драмын эрдмийн театр-ын хамтын ажиллагааны хүрээнд театрын ажилтан, албан хаагчдад Нүд судлалын тасгаас урьдчилан сэргийлэх үзлэгийг зохион байгууллаа.</p> <p>Үзлэгийн үеэр нүдний угийн дурангийн шинжилгээ хийх, хараа шалгах зэрэг оношилгоо хийгдэж, мөн нүдний эрүүл ахуй болон нүдний даралт ихсэх өвчнөөс урьдчилан сэргийлэх талаар сургалт, зөвлөгөө өглөө.</p> <p>Энэхүү үйл ажиллагаа нь нүдний өвчнийг эрт илрүүлэх, урьдчилан сэргийлэх мэдлэг мэдээллийг олон нийтэд хүргэхэд чиглэсэн юм.</p> 

				<p>- □□□ ХАВДРЫН ЭСРЭГ ДЭЛХИЙН ӨДӨР УХТЭ-ийн Ерөнхий мэс заслын тасаг, Хавдрын хими эмчилгээний хэсэг, Дурангийн төв, Цөмийн оношилгоо эмчилгээ төв, Сэргээн засах эмчилгээний тасаг, Хоол шим тэжээлийн тасаг, НЭМТ-ын алба нар хамтран “ХОДООДНЫ ХАВДРААС СЭРГИЙЛБЕ” нээлттэй хаалганы өдөрлөгийг 2026.02.04-нд зохион байгууллаа. Өдөрлөгөөр иргэдэд хавдрын нарийн мэргэжлийн эмчийн зөвлөгөө, эмчилгээний хоол зүйчийн зөвлөгөөг өгч хавдраас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг хийж тэмдэглэн өнгөрүүлээ.</p> 
3.4	Эмнэлгийн нийт ажилчдад ISO 9001:2015 стандарт, магадлан итгэмжлэлийн тухай сургалт, хэлэлцүүлэг зохион байгуулах	Эмнэлгийн нийт ажилчдад ISO 9001:2015 стандарт, магадлан итгэмжлэлийн тухай сургалт, хэлэлцүүлэг зохион байгуулсан тайлан.	Эмнэлгийн нийт ажилчид ISO 9001:2015 стандарт, магадлан итгэмжлэлийн талаар ойлголт, мэдлэг дээшилсэн байна.	2, 4-р улиралд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн.
<p align="center"><b>Зорилт 4: Нотолгоонд суурилсан анагаах ухааныг хөгжүүлэх, эмнэлзүйн удирдамж, заавар, стандарт, эрүүл мэндийн үйлчилгээнд тавих шаардлага стандартын хэрэгжилтийг хангах</b></p>				

4.1	ЭМДҮЗ-ийн тогтоолд заасан чанарын шалгуурын дагуу, эмнэлзүйн удирдамж, заавар, стандарт, эрүүл мэндийн үйлчилгээнд тавих шаардлага стандартын хэрэгжилтийн дагуу хяналтын хуудас боловсруулж хянах	Хяналтын хуудас боловсруулсан тоо, хяналт хийсэн тоо	Эмчилгээ үйлчилгээ стандарт удирдамжийн дагуу хэрэгжинэ.	ЭМДҮЗ-ийн тогтоолд заасан чанарын шалгуурын дагуу ижил мэргэжилтний үнэлгээний хуудсуудыг боловсруулан гаргасан батлуулахаар хянуулж байна.  Шинээр батлагдан мөрдөн ажиллаж байгаа тусламж үйлчилгээний 4 журамд хяналтын хуудас гарган батлуулсан.
4.2	Эмнэлэгт зонхилон тохиолдож байгаа өвчнийг судалж, дүн шинжилгээ хийх (зонхилон тохиолдож байгаа 5 өвчин)	Эмнэлэгт зонхилон тохиолдож байгаа өвчний судалгааны дүн	Эмнэлгийн стратеги төлөвлөлт, нөөцийн хуваарилалт, хүний нөөцийн бодлого, мэргэшлийн сургалт тодорхой үр дүнтэй болно.	2, 4-р улиралд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн
4.3	Хүнд, ховор тохиолдол, нас баралтын хэлэлцүүлэг, morning conference тогтмол хийх	Хүнд, ховор тохиолдлын хэлэлцүүлэг, эмнэлзүй эмгэг судлалын конференц	Эмч, сувилагч нарын мэдлэг, мэргэжил дээшилнэ. Үйлчлүүлэгчдэд үзүүлж буй тусламж үйлчилгээний чанар сайжирна. Эмчилгээ оношилгоонд гарах үл тохирол, ноцтой тохиолдлын тоо багасна.	2026 оны 3 дугаар сарын 20-ний байдлаар Эмнэлгийн нийт <b>44</b> нас баралтаас эмгэг судлалын шинжилгээнд <b>3</b> тохиолдол орсон буюу эмгэг судлалын шинжилгээний хувь 6.8% байна.  Оношийн зөрөө 1 тохиолдол бүртгэгдсэн.  - Голдманы ангиллаар II бүлэг үндсэн оношийн зөрөө-1  Эмнэлзүй ба эмгэг судлалын бага хурал:  Нийт 1 хэлэлцүүлэг хийгдсэн.  - Нийт эмнэлгийн хэмжээнд 1 тохиолдол

				хэлэлцсэн.  4 эхэд эмч нарын хамтарсан зөвлөгөөн хийгдэж эмчилгээ оношилгоотой холбоотой шийдвэр гаргаж хэрэгжүүлэн ажилласан.
<b>Зорилт 5: Үйлчлүүлэгч төвтэй тусламж, үйлчилгээг хөгжүүлэх, тусламж үйлчилгээний таатай орчин бүрдүүлэх, хэрэглэгчийн үнэлгээг тогтмолжуулах</b>				
5.1	“Эрүүл мэндийн үйлчилгээнд тавих шаардлага MNS 7014:2023 стандартыг хэрэгжүүлж ажиллах	Стандартын хэрэгжилтийн хувь Үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамж нэмэгдсэн хувь Үйлчлүүлэгчийн гомдол буурсан хувь	Үйлчлүүлэгч төвтэй эмнэлгийн орчин бүрдсэн байна. Үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамж нэмэгдсэн байна.	Үйлчлүүлэгч төвтэй тусламж, үйлчилгээг хөгжүүлэх, тусламж үйлчилгээний таатай орчин бүрдүүлэх, хэрэглэгчийн үнэлгээг тогтмолжуулах зорилгоор 2026 оны 01 дүгээр сарын 26 -нд УХТЭ-т Мэдрэлийн төв байгуулагдсан нь иргэдэд үзүүлэх мэдрэлийн тусламж, үйлчилгээний хүртээмж, чанарыг дээшлүүлэх, өвчнийг эрт илрүүлэх, урьдлан сэргийлэх, тасралтгүй хийх боломж бүрдүүлснээр Амбулаториор үйлчлүүлж буй иргэдийн сэтгэл ханамжийг 2025 оны 1 дүгээр улиралтай харьцуулахад 22%-аар өссөн байна.
5.2	Үйлчлүүлэгчдийн болон ажилчдын сэтгэл ханамжийн судалгааг авч, дүн шинжилгээ хийж, тайлагнах.	Судалгааны үр дүн, саналд тулгуурлан төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлсэн байна. (сэтгэл ханамжийн хувь)	Үйлчлүүлэгчид болон ажилчдын хэрэгцээг танин мэдэж, үйл ажиллагаандаа хэрэгжүүлсэн байна.	Судалгааг Эрүүл мэндийн сайдын 2022 оны 07-р сарын 01 өдрийн А/346 тоот тушаал гарсантай холбоотойгоор эмнэлгийн байгууллага нь хэрэглэгчдийн сэтгэл ханамжийн үнэлгээ болон эмч, эмнэлгийн ажилтны сэтгэл ханамжийн үнэлгээг байгууллагын онцлогт тааруулан боловсруулан гаргах болсонтой холбоотойгоор 2024 онд Улсын хоёрдугаар төв эмнэлгээс дахин боловсруулсан асуумжийн дагуу авсан. Амбулаториор

				<p>үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн асуумж нь 13 асуулттай. Хэвтэн эмчлүүлэх үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн асуумж нь 14 асуулттай. Эмнэлгийн ажилтны сэтгэл ханамжийн асуумж нь 7 бүлэг, 26 асуулттай судалгааны асуумжаар, цахим хэлбэрээр авлаа.</p> <p>2025 оны 1-р улирлын байдлаар “Амбулаториор үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн судалгаанд” нийт 113 үйлчлүүлэгч судалгаанд хамрагдсан. Амбулаторийн ерөнхий сэтгэл ханамжийн хувь 95%(маш сайн, сайн). “Хэвтэн эмчлүүлэх үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн судалгаанд” нийт 105 үйлчлүүлэгч судалгаанд хамрагдсан. Хэвтэн эмчлүүлэгчдийн ерөнхий сэтгэл ханамжийн хувь 96% (маш сайн, сайн). “Эмнэлгийн ажилтны сэтгэл ханамжийн судалгаанд” нийт 97 эмч, эмнэлгийн ажилчид хамрагдсан байна. Ерөнхий сэтгэл ханамжийн хувь 58.4% (маш сайн, сайн).</p>
--	--	--	--	---

5.3	Өргөдөл, гомдол, санал, талархлыг нэгтгэн судалж, шийдвэрлэх.	Өргөдөл, гомдол, санал, талархлын бүртгэл, түүний дагуу шийдвэрлэсэн байдал.	Өргөдөл, гомдол, саналыг 100% шийдвэрлэсэн байна.	<p>2026 оны 1 дүгээр улирлын байдлаар УХТЭ-ийн ЭМТҮЧАБ-ын албанд нийт 25 өргөдөл гомдол, санал хүсэлт бүртгэгдсэн байна. Талархал нийт-14 бүртгэгдсэн байна.</p> <p>Үүнээс:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Эмчилгээ, үйлчилгээний чанар, хүртээмжтэй холбоотой-18 буюу 72%,</li> <li>·Эмч, ажилчдын мэргэжлийн чадвар, харилцаа, хандлагатай холбоотой-5 буюу 20%,</li> <li>- Эмчилгээний төлбөр, дэмжлэг хүсэхтэй холбоотой-15 буюу 53.5%,</li> <li>- Бусад-2 буюу 8% байна.</li> </ul> <p>Гомдлын төрлөөр нь:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Гомдол-24 буюу 96%</li> <li>- Мэдэгдэл (Хүсэлт)-1 буюу 4%</li> </ul> <p>Нийт ирсэн өргөдөл гомдлын бичгээр-2, утсаар хандсан-1, 1111 төв-21, албан бичгээр-1 байна.</p> <p>Шийдвэрлэлт 100%.</p> <p>1. Эмчилгээ, үйлчилгээний чанар, хүртээмжтэй холбоотой гомдол нийт 18 буюу 72% байна. Үүнд тасаг хоорондын уялдаа холбоо болон хүлээгдэлтэй холбоотой гомдол зонхилж байна. Тухай бүрт нь гомдлыг шийдвэрлэсэн байна.</p>
-----	---	--	---	--

				<p>2. Эмчилгээний төлбөр, дэмжлэг хүсэхтэй холбоотой хүсэлт өргөдлөөр нийт 15 буюу 53.5% ирсэн бөгөөд өргөдлийн дагуу эмийн эмчилгээг зохицуулах хорооны хурлаар хэлэлцэн шийдвэрлэсэн.</p> <p>3. Бусад хэсэгт орсон 2 гомдол буюу 8% нь байна. Утсаар цаг авахтай холбоотой болон 18000119 дуудлагын утасны үйл ажиллагааг УХТЭ хариуцан ажиллаж эхэлж байгаатай холбоотой, тусламж үйлчилгээний товлосон цагаас өмнө үзүүлэх сонирхолтой хүмүүсийн гаргасан гомдол, эмнэлгийн засвар үйлчилгээтэй холбоотой гомдлууд зонхилж байна.</p> <p>4. Эмч, ажилчдын мэргэжлийн чадвар, харилцаа хандлага, ёс зүйтэй холбоотой гомдол нийт 5 буюу 20% байна. Гомдлын дагуу холбогдох тасаг нэгжийн эрхлэгчтэй холбогдон сануулах арга хэмжээ авсан.</p>
--	--	--	--	--

<b>Зорилго 6: Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээтэй холбоотой халдвараас сэргийлэх, хянах тогтолцоог олон улсын жишигт ойртуулах</b>				
6.1	Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээтэй холбоотой халдвар (ЭТҮХХ)-ын эрсдэлийг бууруулж ажиллах.	Батлагдсан ЭТҮХХ-ын тоо	Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээтэй холбоотой халдвар (ЭТҮХХ)-ын эрсдэл буурна.	Ариутгал халдваргүйтгэлийн тасаг, Халдварын сэргийлэлт хяналтын албаны тайланд тусгасан болно.
6.2	Хамрагдвал зохих эрүүл мэндийн ажилтны В вирусийн халдвараас сэргийлэх дархлаажуулалтын хамралтыг нэмэгдүүлэх	В вирусийн эсрэг дархлаажуулалтад хамрагдсан ажилтны хувь	ДЭМБ-ын 2022-2030 оны стратегид тусгасны дагуу 90% хүргэх	
6.3	Гар угаалтын хувь - эрүүл мэндийн ажилтны гар угаалт, халдваргүйтгэлийн түвшинг дээшлүүлэх	Гар угаалтын түвшин 65% байгааг 70% болгоно.	Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээтэй холбоотой халдвар (ЭТҮХХ)-ын эрсдэл буурна.	
6.4	Антибиотикийн дэд хорооны тойролт хийх үйл ажиллагааг төлөвшүүлэх	Зохисгүй хэрэглэсэн антибиотикийн тоо буурах	Эмч нарын антибиотикийн зохистой хэрэглээ төлөвшсөн байна	
<b>Зорилт 7: Эрүүл мэндийн ажилтан болон үйлчлүүлэгчийн аюулгүй байдлыг хангах, тусламж үйлчилгээний эрсдэлийг бууруулах</b>				
7.1	Эмнэлгийн ажилчид болон үйлчлүүлэгчдийн аюулгүй байдлыг сайжруулах, аюулгүй байдалд нөлөөлөх эрсдэлийг илрүүлэх,	Давтан сургалтууд, журам ажлын заавар, тэдгээрийн хэрэгжилт, үйлчлүүлэгчийн аюулгүй байдалтай холбоотой	Эмнэлгийн ажилтан болон үйлчлүүлэгчийн аюулгүй байдалтай холбоотой эрсдэлийг илрүүлж хариу арга	ЭМС-ын 2019 оны 12-р сарын 12-ны А/566 тоот тушаал болон ISO 9001:2015 Чанарын менежментийн тогтолцооны суурь журмын нэг УХТЭ, Ерөнхий захирлын 2025 оны А/192 дугаар тушаал УХТЭ-БМ-06 ЧМТЖ 5:2025-3

	бууруулах арга хэмжээг тогтмолжуулах	эрсдэлийн тоо, тохиолдлын тоо	хэмжээ авснаар аюулгүй байдалтай холбоотой тохиолдлын тоо буурна.	"Эрсдэлийн удирдлагын журам"-ын дагуу эмнэлэгт тохиолдох эрсдэлийг тодорхойлох, үнэлэх, удирдах зэрэг үйл ажиллагаагаар зохицуулж ажиллаж байна. Тус журмын шинэчлэлттэй холбогдуулан ЭМТҮЧАБЭ-ийн албанаас МЭЭТ, ЯТТ, ДОТ тасгуудад журмын танилцуулга болон эрсдэлийн тухай ойлголт, бүртгэх, хариу арга хэмжээ хэрхэн авах талаар сургалтууд орсон.
7.2	Тусламж үйлчилгээ үзүүлэхэд тохиолдох эрсдэлийг тодорхойлох, үнэлгээ хийх, дүн шинжилгээ хийх, эрсдэлийг удирдах	Эрсдэлийн нэгдсэн санд бүртгэгдсэн тоо, эрсдэлийн буурсан хувь	Эрсдэлийг удирдсанаар ноцтой, өндөр эрсдэлүүд буурсан байна.	ЭМС-ын 2019 оны 12-р сарын 12-ны А/566 тоот тушаал болон ISO 9001:2015 Чанарын менежментийн тогтолцооны суурь журмын нэг УХТЭ, Ерөнхий захирлын 2025 оны А/192 дугаар тушаал УХТЭ-БМ-06 ЧМТЖ 5:2025-3 "Эрсдэлийн удирдлагын журам"-ын дагуу эмнэлэгт тохиолдох эрсдэлийг тодорхойлох, үнэлэх, удирдах зэрэг үйл ажиллагаагаар зохицуулж ажиллаж байна. Нийт бүртгэгдсэн 54 эрсдэлээс эрсдэлийн удирдлагын өмнө 1.Бага эрсдэл 0% 2.Дунд эрсдэл 31 буюу 57.4% 3.Өндөр эрсдэл 20 буюу 37.1% 4.Ноцтой эрсдэл 3 буюу 5.5% тус тус байсан бол Эрсдэлийн удирдлагын дараа <b>ноцтой эрсдэл</b> 1 буюу 1.8% болж, <b>өндөр эрсдэл</b> 4 буюу 7.4 хувь болж, <b>дунд эрсдэл</b> 13 буюу 24% болж, бага эрсдэл 36 буюу 66.6% болж тус тус бууруулсан байна.
7.3	Эрсдэлийн удирдлагын хороо шинээр томилж, үйл ажиллагааг тогтмолжуулах	Эрсдэлийн удирдлагын хороо томилогдсон байх, ажиллах журам шинэчлэгдсэн байх,	Хэлэлцсэн асуудал, авсан арга хэмжээний тоо.	Эмнэлгийн Ерөнхий захирлын 2026 оны 02 дугаар сарын 12-ны өдрийн А/15 тоот тушаал "Эрсдэлийн удирдлагын хороо байгуулах тухай" зөвлөлийн бүрэлдэхүүнийг байгуулан

		өндөр болон ноцтой эрсдэл буурсан тоо Хэлэлцсэн асуудал, авсан арга хэмжээний тоо. Эрсдэлээс урьдчилан сэргийлсэн үйл ажиллагааны тоо, хэрэгжилт, үр дүн	Эрсдэлийн хариу арга хэмжээ авсан үйл ажиллагааны тоо, хэрэгжилт, үр дүн.	ажиллаж байна.
7.4	Шинээр нэвтрүүлж буй эмчилгээ, оношилгооны технологи, эмнэлгийн барилга байгууламж шинэчлэгдэн байгуулагдах бүрд эрсдэлийн үнэлгээг хийж, эрсдэлийг бууруулах арга хэмжээ авч ажиллах	Эрсдэлийг бууруулсан, удирдсан тайлан.	Шинээр нэвтрүүлж буй эмчилгээ, оношилгооны технологи, эмнэлгийн барилга байгууламжид тохиолдох эрсдэл буурсан байна.	Бөөр шилжүүлэн суулгах мэс засалтай холбоотойгоор тус ажлын хэсгийн үйл ажиллагаа, тоног төхөөрөмж, хүний нөөцийн мэргэшсэн байдал, хүний нөөцийн бэлэн байдал зэрэгт тулгуурлан эрсдэлийн үнэлгээ хийгдэж байна. Спект СТ нэвтрүүлэхтэй холбоотойгоор ЦОЭТ-д тоног төхөөрөмжийн бэлэн байдал, хүний нөөцийн мэргэшсэн байдал, орчны аюулгүй байдал зэрэгт эрсдэлийн үнэлгээ хийгдсэн.
7.5	Үйлчлүүлэгчийн аюулгүй байдлын дэлхийн өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх	Өдөрлөгийн хүрээнд хийгдсэн үйл ажиллагааны тайлан	Эмч, эмнэлгийн ажилтан үйлчлүүлэгчийн “Үйлчлүүлэгчийн аюулгүй байдлын талаарх” мэдлэг мэдээлэл нэмэгдэнэ.	3-р улиралд 9 сарын 17 нд Үйлчлүүлэгчийн аюулгүй байдлын дэлхийн өдрийг тэмдэглэн өнгөрүүлнэ.
<b>Зорилт 8: Шинэ технологи, сайн туршлага нэвтрүүлэх, тулгамдаж буй асуудлын хүрээнд судалгаа, шинжилгээ хийх</b>				
8.1	Эмнэлгийн тусламж үйлчилгээнд шинэ технологи, шилдэг оношилгоо, эмчилгээ, сувилгааны арга, техник, зайн оношилгооны	Шинэ технологийн тоо, үр дүн	Шинээр нэвтрүүлсэн технологийн үр дүнд тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдал сайжирсан байна.	Бөөр шилжүүлэн суулгах баг томилогдсон ЭМХТ-ийн Эрхтэн шилжүүлэн суулгах үйл ажиллагааг зохицуулах албаны удирдлага болон мэргэжилтнүүд бөөр шилжүүлэн суулгах багтай хамтарсан уулзалт хийж

	дэвшилтэт аргуудыг нэвтрүүлэх			<p>мэргэжил арга зүйн зөвлөгөө өгсөн.</p> <p>Телемедициний тусламж үйлчилгээний хүрээг нэмэгдүүлсэн.</p> <p>Цөмийн оношилгоо эмчилгээний төвд SPECT CT шинээр суурилуулсантай холбоотой туршилтын тохиолдлуудад шинжилгээ хийгдсэн.</p>
8.2	Сайн туршлага нэвтрүүлэх	Нэвтрүүлсэн сайн туршлагын тоо, үр дүн	Сайн туршлагын үр дүнд тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдал сайжирсан байна.	Элэг шилжүүлэн суулгасан тохиолдол тус бүрийн эмнэлзүйн хамтарсан хэлэлцүүлгийг УНТЭ-ийн эрхтэн шилжүүлэн суулгах багтай хамтран хийж хэвшсэн. Одоо 3 сарын 25 -ны өдөр манай эмнэлэг дээр ээлжит хэлэлцүүлгийг хийхээр товлосон.